

# “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”


## Гурав. Онц байдлын үеийн МҮОНТВ ба төрийн цензур

2008 оны 7 сарын 1-ний өдрийн Ерөнхийлөгчийн зарлигаар онц байдал тогтоосноос хойш дөрөв хоногийн хугацаанд МҮОНТВ дангаар ажилласан билээ. Энэ хугацаанд төрөөс МҮОНТВ-д хатуу цензурээ сэргээн тогтоож, төрийн удирдлагад авсан юм. Ингэснээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн дуу хоолойг боомилон, олон нийтэд хүрэх мэдээллийн олон ургальч чанар алдагдаж, улс төрийн хүрээн дэх цөөнх, нийгэм дэх жирийн иргэн, эрдэмтэн, шинжээчдийн байр суурь дарагдаж, оюун санааны хүрээнд догматик хандлага давамгайлж, нийгмийн шударга ёс алдагдахад хүргэсэн гэж үзэж байна.

МҮОНТВ, 2008 оны 07 сарын 05-ны 00:11-00:21 цаг, 618 секунд

... Онц байдал цуцлагдлаа. Өнгөрсөн хугацаанд МҮОНТВ нь Онц байдлын тухай хуульд захирагдаж Үндэсний Аюулгүй байдлын Шуурхай штабын шууд удирдлаган дор тус штабын мэдээлэлд үндэслэн мэдээллээ дамжуулж байсан ...

Төрийн хяналттай өдрүүдэд МҮОНТВ-ийн дэлгэцнээ гарсан эх сурвалжийн 51.1 хувь нь албаны буюу засгийн газрын төлөөлөл байв. Иргэд 4.1 хувь, төрийн бус байгууллагын төлөөлөл 3.2 хувийг эзэлсэн бол шинжээч, ажиглагч ердөө 0.1 хувьтай байлаа.





# “7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

7 сарын 1-ний өдөр үүссэн нөхцөл байдлын шалтгааныг МАХН сонгууль будлиантуулсан (25.3%)-ны үр дагавар, Ардчилсан намын дарга Ц.Элбэгдоржийн турхиралтаас(14.4%) болсон гэсэн тайлбар зонхилж байсан бол онц байдлын үеэр хэд дахин буурч, онц байдал цуцлагдсаны дараа МАХН-ыг буруутгасан мэдээлэл давамгайлж, дараа нь сонгуулийн үр дүн нийгмийн хүлээлттэй зөрчилдсөн тухай тайлбар 10.4 хувийг эзэлжээ.



Дээрхи графикаас онц байдлын үеэр МҮОНТ үүссэн нөхцөл байдлын шалтгааны үр дагаврын тухай хэрхэн мэдээлсэнийг харж болно.

Энэ хэрэг явдлаас үүдэн цагдаа, гэмтэж бэртсэн тухай мэдээлэл 18.6 хувь эзэлжээ. Дараа нь соёлын өв шатсан (14.5%), хүний амь эрсэдсэн (11.2%) тухай мэдээлэл орсон байна. Сэтгүүлч гэмтэж, бэртсэн, МАХН-ын байрыг шатаасан, урлагийнхан тоглолт хийж чадахгүйд хүрсэн, цагдаагийн зэвсэг хэрэгсэл хангалтгүй, бизнесд нөлөөлсөн, Монгол Улсын нэр хүндэд муугаар нөлөөлж, жуулчдын тоо багасна гэх мэт 12 төрлийн мэдээлэл тус бүрийн эзлэх хувь таван хувиас доош байлаа.